

**КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГЫГ СОНГОХ ТУХАЙ**





Компанийн тухай хуулийн 78-р зүйлийн 78.1. дэх заалт, нэр дэвшүүлэх хорооны саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**





1. ТУЗ-ийн хуралд оролцсон нийт есөн гишүүний 100 хувийн саналаар ТУЗ-ийн гишүүн Д. Машбатыг ТУЗ-ийн даргаар сонгосугай.

2. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, журмаар тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ТУЗ-ийг удирдан зохион байгуулж ажиллахыг Д. Машбат-д үүрэг болгосугай.



ТУЗ-ийн гишүүд:  
1. С. Багшилэг

- 2. Д. Батсайхан 
- 3. Х. Мухаметгалим 
- 4. Р. Сайдаброр 
- 5. Т. Камолиддин 

- 6. Р. Отгонбат 
- 7. Ц. Сарантуяа 
- 8. Д. Машбат 
- 9. А. Ариунтуяа 

Огноо: 2023.05.19

№ 23/01

Улаанбаатар

**ТУЗ-ИЙН ХОРООДЫГ БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 81-р зүйлийн 81.2. дах заалт, ТУЗ-ийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн Аудитын хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
  1. С. Батбилэг /Дарга/
  2. Д. Машбат
  3. Х. Мухаметгалим
2. ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
  1. Р. Отгонбат /Дарга/
  2. Х. Мухаметгалим
  3. С. Батбилэг
3. ТУЗ-ийн Цалин урамшууллын хорооны гишүүдээр дараах нэр бүхий гурван гишүүнийг сонгосугай.
  1. Т. Камолиддин /Дарга/
  2. С. Батбилэг
  3. Х. Мухаметгалим
4. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, Хороодын үйл ажиллагааны журмаар тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг Хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.



**Д.МАШБАТ**



Огноо: 2023.05.19

№ 23/  
109.

Улаанбаатар

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ  
СОНГОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.8 дэх заалт, ТУЗ-ийн даргаас оруулсан саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компанийн 2023 оны 5-р сарын 19-ний ТУЗ-ийн хуралд оролцсон нийт 9 гишүүний 100 хувийн саналаар Рустамходжаев овогтой Сайдаброрыг Гүйцэтгэх захирлаар улируулан ажиллуулсугай.
2. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, хөлсөөр ажиллах гэрээнд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг шинээр сонгогдсон Гүйцэтгэх захирал Р. Сайдаброрт үүрэг болгосугай.



Д.МАШБАТ

**КОМПАНИЙН ТУЗ-ИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГЫГ ТОМИЛОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.8 дэх заалт, ТУЗ-ийн даргаас оруулсан саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ТУЗ-ийн хуралд оролцсон нийт 9 гишүүний 100 хувийн саналаар Аззаяа овогтой Амирланг компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар томилсугай.
2. ТУЗ-ийг төлөөлөн гэрээнд гарын үсэг зурахыг ТУЗ-ийн дарга Д. Машбат-д зөвшөөрсүгэй.
3. Компанийн тухай хууль, компанийн дүрэм ТУЗ-ийн үйл ажиллагааны жухам болон ажил гүйцэтгэх гэрээнд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг А Амирланд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Д.МАШБАТ

Огноо: 2023.05.19

№ 23/  
11

Улаанбаатар

**“МОРЬТ ИМПЕКС” ХХК-ТАЙ БАЙГУУЛСАН  
ГЭРЭЭГ ШИНЭЧЛЭН СУНГАХ ТУХАЙ**

Компанийн 2023 оны 4 сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 23/05 дугаар шийдвэрийн тогтоолд үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч байсан Г. Ганбатын “Морьт Импекс” ХХК-наас авах авлагын дүнг баталгаажуулан, түүнтэй байгуулсан гэрээг шинэчлэн байгуулсугай.
2. Гэрээг шинэчлэн хийх, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалан гэрээний дагуу компанийн өр төлбөрийг барагдуулан ажиллах болон шинэчилсэн гэрээг ТУЗ-д танилцуулахыг Гүйцэтгэх Захирал Р. Сайдаброр-т үүрэг болгосугай.



**Д.МАШБАТ**



Огноо: 2023.05.19

№ 23/  
112

Улаанбаатар

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ТОМИЛОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.8 дэх заалт, ТУЗ-ийн даргаас оруулсан санал болон Гүйцэтгэх Захирал Р.Сайдаброрын өөрийн гаргасан хүсэлтэнд тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Фронтнер Лэнд Групп” ХК-ийн Гүйцэтгэх Захирал Р. Сайдаброр-ийн гаргасан хүсэлтийн дагуу 2023 оны 05-р сарын 19-ний өдрөөр тасалбар болгон хугацаагүйгээр түр ажлаас чөлөөлсүгэй.
2. Гүйцэтгэх Захирал ажлаас түр чөлөөлөгдөж байгаатай холбогдуулан “Фронтнер Лэнд Групп” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Т. Камолиддин-ийг 2024 оны 4-р сарын 30-ыг дуустал Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.
3. Гүйцэтгэх Захирал Р. Сайдаброртой ажил хүлээлцэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т. Камолиддинд даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хороо, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд тус тус даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

